



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 23/005

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дах хэсэг, 76 дугаар зүйл 76.1.2 дах хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Бямба гарагт 11:00 цагт Монгол улс, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж, Реженси резиденс, 2 давхарт 203 тоот танхимд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
Үүнд:

- 2.1.1. Компанийн 2022 оны Бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- 2.1.2. Компанийн 2022 оны Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- 2.1.3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 2.1.4. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
- 2.1.5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;

- 2.1.6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалт, бусад холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.
 5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг хавсралтаар баталсугай. /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2023 оны 4 дүгээр сарын 15 өдрийн 11 цаг 00 минут хүртэл байна./
 6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Хатанболдыг томилсугай.
 7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Г.Янжинлхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Б.Мөнхцэлмүүн /Захиргаа, хүний нөөцийн мэргэжилтэн/
Д.Билэгжаргал /Хэрэглэгчийн үйлчилгээний мэргэжилтэн/
 8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Янжинлхамд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ХАТАНБОЛД



**АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 3 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар *23/006*

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Айтүүлс ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Жигжид /Борлуулалтын мэргэжилтэн/

Комиссын гишүүд:

- ✓ Э.Ганзориг /Хөгжүүлэгч /
 - ✓ Х.Уянга /Харилцагчийн үйлчилгээний мэргэжилтэн /
2. Тооллогын комисс (Д.Жигжид)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:
 - 2.1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх.
 - 2.2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох.
 - 2.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх.
 - 2.4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах.
 - 2.5. Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх.

- 2.6. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах.
- 2.7. Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

